

# “ЭМ ЭН ДИ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 03 сарын 20-ны өдөр

Дугаар: 04/25

Улаанбаатар хот

*Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай*

ЭМ ЭН ДИ ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал-ыг зарлан хуралдуулах асуудлыг хэлэлцээд Компанийн тухай хуулийн 60.1, 60.2, 60.4, 64, 65,67, дугаар зүйлийн 67.1 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.2, холбогдох заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хурлын тов  
1.1 “Эм Эн Ди” ХК-ний хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 04-р сарын 30-ны 11:00 цагт Кэй эйч тауэр 2 давхарт хурлын танхимд хуралдуулахаар тогтоосугай.
2. Хэлэлцэх асуудал, санал хураах журам  
Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэхээр баталсугай. Үүнд:
  - 2.1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах,
  - 2.2. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэн батлах,
  - 2.3. Компанийн ноогдол ашиг тараахгүй байх ТУЗ-ийн гаргасан тогтоолын танилцуулах
  - 2.4. ТУЗ-ийн бүрэн эрхийг бүрэн бүрэлдэхүүнээр нь дуусгавар болгож, ТУЗ-ийн гишүүдийг кумулятив аргаар сонгох тухай
  - 2.5. ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай
3. Санхүүгийн зохицуулах хорооны журмын дагуу “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг Хавсралт № 1 баталж, 2025оны 03 дугаар сарын 24-ны өдрийн дотор багтаан Санхүүгийн зохиуцлах хороо болон Монголын Хөрөнгийн Биржид хүргүүлсүгэй.
4. Бүртгэл, мэдээлэл хүргүүлэх

Хувьцаа эзэмшигчдийн ээлжилт хурлын зарыг Хавсралт № 2 -оор баталж, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид хүргүүлж, “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмын” дагуу 2025 оны 03-р сарын 24-ны өдөр болон 2025 оны 04 дүгээр сарын 09-ны өдрүүдэд өдөр тутмын сониноор дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх, анх мэдээлсний дагуу дахин хурлын зарыг хүргэхээр тогтоосугай.

Мөн санал хураалтыг хурлын үеэр авахаас гадна урьдчилсан байдлаар компанийн шуудангийн хаяг, и-мэйл хаягаар дамжуулан авах Санал авах хуудасны загварыг Хавсралт 3-ээр баталсугай.

5. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийг 2025 оны 03 сарын 24-ний өдрийн дотор үнэт цаасны компаниудад цахим хэлбэрээр хүргүүлсүгэй.
6. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 04 сарын 09-ны өдөр байхаар тогтоосугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжилт хуралд биечлэн оролцох боломжгүй, саналын хуудсаар дамжуулан урьдчилан саналаа ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийг хуралд оролцсон гэж үзэх бөгөөд саналын хуудсыг хүлээн авах сүүлийн хугацааг 2025 оны 04 дүгээр сарын 09-ны өдрийн 18:00 цаг хүртэл тогтоосугай.
8. Хурлын зохион байгуулалт
  - 7.1 Хурлын дэгийг хавсралт 4-аар баталсугай.
  - 7.2 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Н.Ганчимэг-ыг томилсугай.
  - 7.3 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын даргаар Э.Ууганболд-г томилсугай.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын бэлтгэлийг хангаж, хэлэлцэх асуудалтай холбоотой баримт бичиг, мэдээллийг бэлдэх, дэгийн дагуу зохион байгуулж, хурлын шийдвэр болон холбогдох баримт бичиг, тайлан мэдээллийг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн Биржид хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Б.Эрдэнэтуяа/-д даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Н.ГАНЧИМЭГ